



СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2022 он

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК-ийн товч мэдээлэл:

Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимп, Реженси барилга 204 тоот

Гүйцэтгэх захирал: Б.Сугарсүрэн

Хувьцаа эзэмшигчид:

Аудитын компани: Сэргэлт Дөл Аудит ХХК

Үйл ажиллагааны зөвшөөрөл: Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны **23-2015** дугаарын тусгай зөвшөөрөлтэй.

Албан ёсны хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын гудамж, Peace building . 302 тоот

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;

Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2022.03.31 № СТА/22-48

танай _____ -ны № _____ -т

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Люкс Занаду Групп” ХК-НИЙ 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН, ЖИЛИЙН ЭЦСЭЭРХ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН, МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙГ БАГТААСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛЭС БҮРДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материалыг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэ тайлангийн Санхүүгийн Тайллагний Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайллагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материалыг алдаатай тайллагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг байнга илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг. Бид засаглах удирдлагатай аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид “Люкс Занаду Групп” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд доорх зүйлээс бусад зүйлсийн хувьд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

- Компани тайлант жилд МУ-ын Компанийн тухай хуулийн 89-р зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ уг хуулийн 92.1 Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанийтай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл/ байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана гэсэн заалтыг мөрдөөгүй буюу мөрдсөнөө баримтжуулаагүй байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасны дагуу зөвхөн “Люкс Занаду Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
2022 оны-р сарын.....



Д.АЛТАНЦЭЦЭГ
Захирал, ММНБ

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,480.2	2,876.0
Дансны авлага	19,608.4	19,608.4
Татвар НДШ-ийн авлага		
Бусад авлага		
Бараа материал		
Урьдчилж төлсөн зардал тооцоо		
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>25,088.6</u>	<u>22,484.4</u>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	32,349.0	32,349.0
Биет бус хөрөнгө		
Биологийн хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>32,349.0</u>	<u>32,349.0</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>57,437.6</u>	<u>54,833.4</u>
Дансны өглөг	6,350.1	6,350.1
Цалингийн өглөг		
Татварын өр	1,543.7	
НДШ-ийн өглөг	2,399.8	2,399.8
Урьдчилж орсон орлого	6,000.0	6,000.0
Бусад богино хугацаат өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	<u>16,293.6</u>	<u>14,749.9</u>
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөрийн дүн	<u>16,293.6</u>	<u>14,749.9</u>
Хувийн өмч	6,310.9	6,310.9
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	34,714.5	34,714.5
Хуримтлагдсан ашиг	118.6	-941.9
Эздийн өмчийн дүн	<u>41,144.0</u>	<u>40,083.5</u>
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	<u>57,437.6</u>	<u>54,833.4</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)		
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг /алдагдал/		
Түрээсийн орлого		
Хүүний орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал		1,060.5
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		-1,060.5
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)		-1,060.5
Орлогын нийт дүн		-1,060.5
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Дүн
<u>2020 оны 01 сарын 01-ний улдэгдэл</u>	<u>6,310.9</u>	<u>34,714.5</u>	<u>118.6</u>	<u>41,144.0</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	6,310.9	34,714.5	118.6	41,144.0
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				
<u>2020 оны 12 сарын 31-ний улдэгдэл</u>	<u>6,310.9</u>	<u>34,714.5</u>	<u>118.6</u>	<u>41,144.0</u>
Залруулсан үлдэгдэл	6,310.9	34,714.5	118.6	41,144.0
Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал)			-1,060.5	-1,060.5
<u>2021 оны 12 сарын 31-ний улдэгдэл</u>	<u>6,310.9</u>	<u>34,714.5</u>	<u>-9419.</u>	<u>40,083.5</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2020.12.31	2021.12.31
Мөнгөн орлогын дүн (+)		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн (-)		2,604.2
Ажиллагчдад төлсөн		
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
Бараа материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн		
Түвш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	1,543.7	
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	1,060.5	
YY Ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-2,604.2
Мөнгөн орлогын дүн		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүний орлого		
Мөнгөн зарлагын дүн		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
XO-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Бусад		
Мөнгөн зарлагын дүн		
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
CY Ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		-2,604.2
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,480.2	5,480.2
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,480.2	2,876.0

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

1. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

“Люкс Занаду Групп” ХК (цаашид “компани” гэх) нь Гадаад худалдаа, Мэдээллийн технологи, Интернет цахим хуудасны үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг.

Компани нь 2009 оны 07 сарын 09-нд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үүсгэн байгуулагдсан Хувьцаат компани юм.

Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, УБ хот, СБДүүрэг, 1-р хороо, Олимп, Реженси Барилга 204 тоот албан ёсны хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Улсын бүртгэлийн дугаар: 9010001091 тоот

Регистрийн дугаар: 2050153 тоот

Өмчийн хэлбэр: Компани нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг 15 гишүүнтэй байгууллага. Дүрмийн сан 8,287.1 мянган төгрөг ба нэг бүр нь төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ширхэг энгийн хувьцаатай байна.

Тайланг хамарсан хугацаа: 2021 оны 1-р сарын 1-нээс 2021 оны 12-р сарын 31

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ

2.1 Мөрдсөн стандарт

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлгнасан болно.

2.2 Тайлан бэлтгэх үндэслэл тайлангийн суурь

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлгнасан болно.

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт зарчимд үндэслэн бэлтгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн.

2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан бүх санхүүгийн үзүүлэлтүүд нь мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх оны аудитлагдсан үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

2.4 Тасралтгүй байх зарчим

Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйн ашигтай үйл ажиллагаа, эерэг мөнгөн урсгал ба эсвэл хувь нийлүүлэгчдээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэхээс хамаарна. Компанийн хөрөнгө оруулагчдын зүгээс Компанийг хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгөөр хангах учраас Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх болно гэсэн төсөөллийн үндсэн дээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэсэн.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт

2021 оны 1 сарын 1-нээс эхлэн заавал мөрдөхийг шаардаагүй буюу хүчин төгөлдөр болох хугацааг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш байхаар заасан өөрчлөлт бүхий стандартууд доорх стандартууд байна. Үүнд:

- | | |
|---|---|
| • СТОУС 16 Түрээс | Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлт, Тодруулга, хүчин төгөлдөр болох хугацаа, Шилжилт |
| • НББОУС 41 Хөдөө Аж Ахуй | Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгийн татвар барагдуулалт, хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт |
| • СТОУС 16 | Ковид 19-ийн нөлөөллийн улмаас турээслэгч талд олгох түрээсийн хөнгөлөлт |
| • СТОУС 3 Бизнесийн нэгдэл | Санхүүгийн Тайллагналын Онолын Узэл Баримт-лалтай холбоотой орсон өөрчлөлт |
| • НББОУС 37 Нөөц, Болзошгүй
Өр төлбөр ба Болзошгүй хөрөнгө | Алдагдалтай гэрээ-Гэрээг биелүүлэх зардал шилжилтийн нөхцөл |
| • НББОУС16 Үндсэн хөрөнгө | Үндсэн хөрөнгө-Зориулалтын дагуу ашиглахын өмнөх цэвэр орлого |

Гадаад валютын өөрчлөлт

Компанийн санхүүгийн тайлан нь мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн (Монгол банк)-ны ханшаар дахин хөрвүүлдэг.

Мөнгөн зүйлсийн төлөгдөх эсвэл хөрвүүлэх үед үүссэн бүх зөрүү нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдана. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээ хийсэн өдрийн ханшаар бүртгэнэ. Мөнгөн бус мэдээллийн өөрчлөлттэй холбоотой ашиг, алдагдал боломжийн үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдалтай харьцуулна. (Тухайлбал: бодит үнэ цэнийн олз, гарз нь “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д, бүртгэгдсэн зүйл дээр ханшийн хөрвүүлэлтээс үүсэх олз, гарз нь мөн адил “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д тус тус бүртгэгдэнэ.)

Төгрөгийн нэгж ам доллартай харьцах ханш 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 ам долларт = 2,849.34 төгрөг (2020: 1 ам доллар=2,849.89).

2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээс хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татвар эсвэл хураамжийг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Борлуулсан барааны болон үйлчилгээний өртөг

Борлуулсан барааны өртөг нь тухайн барааны эрсдэл нь худалдан авагч талд шилжсэн үед буюу бараа материалыг худалдан авагчид өгсөн үед хүлээн зөвшөөрөгднө. Борлуулсан барааны орлого нь барааны оронд хүлээн авсан болон хүлээн авах авлагаас буцаалт болон хөнгөлөлт мөн хямдral болон их хэмжээний худалдан авалтын урамшууллыг хассан бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

Шимтгэлийн борлуулалтын орлого

Шимтгэлийн борлуулалтын орлого нь худалдааны зуучлах үйл ажиллагаа хэрэгжих үед хүлээн зөвшөөрөгднө.

Түрээсийн орлого

Түрээсийн орлого нь үйл ажиллагааны түрээсийн нөхцлийн дагуу шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрөгддөг.

Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг бүртгэхдээ үр ашигт хүүний арга ашиглан бүртгэнэ. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд хүлээгдэж буй орох, гарах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэгслийн эргэн төлбөр хийх хугацаа ба түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг бодитойгоор тооцох хүү юм.

Зардлууд

Зардтууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийн бууралт (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт) - ыг үүсгэж буй эдийн засгийн үр ашгийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Ерөнхий болон удирдлагын зардал, борлуулсан барааны өртөг, бусад зардал, санхүүгийн зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн зардал

Тухайн гэрээ нь түрээсийн эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулгад үндэслэх ба гэрээг гүйцэтгэхдээ тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх болон гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай. Компани нь түрээслэгч үед үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Зээлийн зардал

Хөрөнгийн худалдан авалт, бүтээн байгуулалт эсвэл төлөвлөсөн зориулалт эсвэл борлуулахад бэлэн болгоход ихээхэн хэмжээний цаг хугацаа шаардлаг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулдаг. Бусад зээлийн зардал нь зардал гарсан тайлант хугацааны зардлаар бүртгэгдэнэ. Зээлийн зардалд хүү болон Зээлтэй холбоотой байгууллагаас гарсан бусад бүх зардлыг оруулан тооцдог.

Богино хугацааны тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардуудыг Компанийн ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг bogino хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалzan олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө. Компани хуулинд зааснаас өөр тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хөтөлбөрт төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

Тайлант хугацааны орлогын албан татвар

Компани нь Монгол Улсын Засгийн газрын дүрэм журмын дагуу татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог. Тайлант хугацааны болон өмнөх тайлант жилүүдийн орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас авахаар эсвэл тэдгээрт төлөхөөр хүлээж буй дүнгээр хэмжсэн. Эдгээр дүнг тооцоход ашигласан татварын хувь хэмжээ ба татварын хуулиуд нь тайлант хугацааны эцэст хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Хойшлуулсан албан татвар

Санхүүгийн байдлын тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Өр төлбөрийн арга"-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын өр төлбөр нь түр зөрүүнд хүлээнд зөвшөөрөгднө. Хойшлогдсон албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайпант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр өөрийн хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөгүй, хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тайлагналын өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эсвэл үйлчилж хараахан эхлээгүй байгаа татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах, тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь татвар төлөгч нэг аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон орлогын татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

Нэмэгдсэн өргтийн албан татвар

Орлого, зардал ба хөрөнгө нь НӨАТ-ын дүнг хассаны дараа хүлээн зөвшөөрөгдөнө.

Үнд:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өргтийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиromжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Борлуулалт худалдан авалттай холбоотой НӨАТ нь санхүүгийн байдлын тайландаа цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх ба өөрөөр хэлбэл НӨАТ-ын авлага болон өглөгийн цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайлангийн өглөг эсвэл авлагын хэсэгт тусгагддаг. Авлагын үнэ цэнийн бууралтанд нөөц байгуулсан тохиолдолд харилцагч талаас авах НӨАТ агуулсан нийт дүнгээс тооцсон байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өргтгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцож тусгана. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, импортын татвар, татварууд болон хөрөнгийг ашиглалтанд оруулахтай холбогдон гарсан шууд зардлууд орно.

Үндсэн хөрөнгө анх үнэлж байсан стандарт гүйцэтгэлээс илүү гарч түүнийг ашиглахтай холбогдон гарсан зардал ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг өсгөсөн нь тодорхой болсон бол зардлыг үндсэн хөрөнгийн нэмэлт өргтгөөр капиталжуулна.

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасах үед тухайн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын дүнг оролцуулан данснаас хасах бөгөөд үүнээс үүсэх аливаа олз, гарзыг тайлант жилийн орлого, үр дүнгийн тохирох хэсэгт бүртгэнэ.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Монгол Улсын 2019 оны 03 сарын 22-ны өдөр шинэчлэн батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг доорх хувь хэмээргээр байгуулна гэж заасан.

№		Ашиглах нийт хугацаа /жилээр/	
	Хөрөнгийн бүлэг	Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд	Бусад
1	Барилга байгууламж, газрын тохижилт	40	25
2	Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10	
3	Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж	2	
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд	
5	Бусад хөрөнгө	10	

МУ-ын Татварын хуулинд Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно гэсэн заалт байдаг боловч тухайн байгууллага элэгдэл тооцох ямар аргыг хэрэглэж байгаагаа өөрийн байгууллагын НБББодлогодоо тусган өгч зөрүүг Татвар Санхүүгийн тайлангийн зөрүүг зохицуулах журмын дагуу зохицуулж явна.

Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно.) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарз нь цэвэр борлуулалтын орлого болон хөрөнгийн бүртгэлийн үнийн зөрүүгээр хэмжигдэх ба олз, гарзыг биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед орлого, зардлын дансанд бүртгэнэ. Компанийн биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамжийн лицензүүд байх бөгөөд хүлээгдэж буй гурваас (3) арван (10) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дун юм.

Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалаа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ.

Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах болон урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайландаа эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илрэх үед болон хөрөнгийн (бараа материал болон санхүүгийн хөрөнгөөс бусад) бүртгэлийн дүнгүүд үнэ цэнийн бууралт агуулж буй эсэхийг шалгах шаардлагатай болсон тохиолдолд хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно. Хөрөнгийн нөхөгдөх дүн нь хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дун ба түүний бүртгэлийн дун хоёрын аль өндөр нь байх бөгөөд хөрөнгө нь бусад хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгөөс хамааралгүйгээр мөнгөн урсгалыг бий болгохгүй байвал хөрөнгө нэг бүрийн нөхөгдөх дүнг тодорхойлно.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг зөвхөн хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөнд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зохих (үнэ цэнэ нь буурсан хөрөнгийн ажиллагаанд хамарагдах) зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө

Компанийн санхүүгийн хөрөнгө нь бусад авлага болон касс ба харилцах данс дахь бэлэн мөнгө зэргээс бүрдэх бөгөөд зээл ба авлага гэж ангилагддаг. Санхүүгийн хөрөнгийг арилжаа хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрнө.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХХ

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм. Аихны хэмжилтийн дараа эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн хорогдлын дүнг үр ашигт хүүний арга ашиглан гаргадаг ба түүнээс үнэ цэнийн бууралтыг хасаж өгдөг. Хорогдуулалт нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд багтана. Үндсэн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан эсвэл эрхээ шилжүүлэн өгсөн, Компани нь тухайн хөрөнгийн эрсдэл болон өгөөжийг шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

Санхүүгийн өр төлбөр

Компанийн санхүүгийн өр төлбөрт дансны болон бусад өр төлбөрүүд багтана. Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн оролцогч тал болох үед санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Аих хэмжсэний дараа, санхүүгийн өр төлбөрийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан ертгөөр нь хэмжинэ. Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цээз

Боломжийн үнэ гэдэг нь: хөрөнгөө борлуулаад хүлээн авч болох үнэ эсвэл хэмжилтийн огнооны зах зээлийн оролцогчийн хооронд хийсэн өр төлбөрийг шилжүүлэн төлөх үнэ юм. Боломжийн үнийн хэмжилт нь таамаглал дээр суурилсан байх бөгөөд хөрөнгө борлуулсан гүйлгээ эсвэл өр төлбөрийн шилжүүлэг юм.

- Хөрөнгө болон өр төлбөрийн үндсэн зах зээл
- Үндсэн зах зээл байхгүй нөхцөлд хөрөнгө , өр төлбөрийн хамгийн ашигтай зах зээлд

Компани нь үндсэн эсвэл хамгийн ашигтай зах зээлийг хэрэглэх боломжтой байна.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн боломжийн үнэ нь хөрөнгө эсвэл өр төлбөрийг үнэлэж байгаа болон эдийн застгийн хамгийн сайн зах зээлийн оролцогч байдлаар ашиглагдаж хэмжигдэнэ.

Санхүүгийн бус хөрөнгийн боломжийн үнийн хэмжилт нь хамгийн өндөр, хамгийн сайн борлуулалтыг ашиглан өөр зах зээлийн оролцогчид борлуулж эдийн застгийн ашиг хүртэх боломжтой зах зээлийн оролцогчийн авч үздэг.

Боломжийн үнийн бүхий л хөрөнгө болон өр төлбөр нь шатлан захирах үнэлгээний хүрээнд санхүүгийн тайланд илэрхийлэгддэг бөгөөд боломжийн үнийн үнэлгээ нь хамгийн доод түвшинд суурилсан байdag.

- 1-р түвшин: Хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн үнэлэсэн (тохируулаагүй) зах зээлийн үнэ
- 2-р түвшин: Шууд болон шууд бус байдлаар илэрхийлэгдэх боломжийн үнийн үнэлгээнд чухал ач холбогдолтой хамгийн бага түвшиний үнэлгээний техникиуд

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

- 3-р түвшин: Бүртгэсэн бодит үнэ цэнд томоохон нөлөө үзүүлэх, ажиглаж үл болохуйц зах зээлийн өгөгдөл дээр суурилсан өгөгдлүүдийг ашигладаг техникиуд

Санхүүгийн тайлангуудад байнга хүлээн зөвшөөрөгддөг хөрөнгө, өр төлбөрийн хувьд Компани нь тайлант хугацааны эцэс бүрд ангилыг дахин үнэлэн (бодит үнэ цэнийн хэмжилтэд бүхлээрээ үзүүлэх нөлөөний түвшинд суурилан) түвшингүүдийн хооронд шилжилт байгаа эсэхийг тодорхойлдог.

Эздийн өмч

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгийн ангилалд оруулна. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчийн дүнд тусгадаг.

Хувьцааг нэмэгдэлтэй зарсан тохиолдолд нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг хувьцааны нэмэгдлээр бүртгэнэ.

Хувьцааны нэмэгдэлд мөн хувьцаа эзэмшигчдийн оруулсан нэмэлт хөрөнгө оруулалт багтана.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайландаа бэлэн мөнгө ба банкны үлдэгдэл нь банкинд бэлэн мөнгөөр хийгддэг

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгөн хөрөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө ба үнэ цэнэ нь өөрчлөгдөх эрсдэл багатай банкуудад хамаарна.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлаас зарласан ноогдол ашигийг хассан дүнг илэрхийлнэ.

Сангүүд

Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Компани нь байгуулсан сангийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нь нөхөн төлбөрт зарцуулахаар хүлээж байгаа үед (жишээ нь: даатгалын гэрээний үед), нөхөн төлбөр хийх нь бодитой болсон үед л зөвхөн нөхөн төлбөрийг тусдаа хөрөнгө болгон хүлээн зөвшөөрнө.

Болзошгүй үйл явдал

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшаа урсаа боломжгүй биш л бол эдгээр өр төлбөрийн талаар санхүүгийн тайландаа тодруулга хийж өгнө.

Тайлагналын дараах үйл явдлууд

Тайлагналын хугацааны эцэс дэх Компанийн санхүүгийн байдал (залруулах үйл явдлын тухай) нэмэлт мэдээллийг гаргаж өгдөг жилийн эцсийн үйл явдлыг санхүүгийн тайланд тусгана. Залруулга шаардахгүй, материаллаг хэмжээтэй, тайлант хугацааны дараах үйл явдлуудыг санхүүгийн тайланд тодруулж өгнө.

Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь: Компанитай холбоотой этгээд юмуу эсвэл компани юм.

Тухайн хүний эсвэл тухайн хүний гэр бүлийн гишүүн нь Компанид хамааралтай бол:

- i. Компанийн хяналт эсвэл хамтын хяналттай;
- ii. Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй;
- iii. Компанийн гол удирдах боловсон хүчин эсвэл компанийн нэгдмэл гишүүн

Байгууллага нь дараах нөхцлүүдийн аль нэгийг мөрдөж байвал дараах аж ахуйн нэгжтэй холбоотой байна. Үүнэл:

- i. Байгууллага ба Компани нь нэг груптын гишүүд (өөрөөр хэлбэл, толгой компани болон охин компани нь бусадтай холбоотой) гэсэн уг юм.
- ii. Нэг аж ахуйн нэгж нь бусад аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр (эсвэл бусад аж ахуйн нэгжийн гишүүн байх булгээр ажилладаг хараат компани эсвэл хамтарсан компани) юм.
- iii. Аливаа аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хамтарсан компани юм.
- iv. Нэг аж ахуйн нэгж гуравдагч этгээдийн хамтарсан компани бөгөөд бусад аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хараат компани юм.
- v. Аж ахуйн нэгж нь Компанитай холбоотой аж ахуйн нэгжийн аль алиных нь ажилтнуудын ашиг тусын төлөө ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө юм. Компани өөрөө ийм төлөвлөгөөтэй байгаа бол ивээн тэтгэгч ажил олгогч нь компанийтай холбоотой.
- vi. Байгууллага нь Компанийн хяналт, хамтарсан хяналттай этгээдийн хяналтанд байдаг эсвэл хамтран хяналт тавьдаг.
- vii. Байгууллага буюу түүний хэсэг нь аливаа нэг гишүүн нь Компанийн удирдлага эсвэл компанийн толгой компанид удирдах гол боловсон хүчинд үйлчилгээ үзүүлдэг.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

Санхүүгийн тайлангийн тодруулгүүд

4. Мөнгө ба түүнтэй ажилтгах хөрөнгө

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	/мянган төгрөгөөр/
Касс дахь мөнгө	5,480.2	2,876.0	
Банкин дахь мөнгө			
Нийт дүн	5,480.2	2,876.0	

Банкин дахь төгрөгийн харилцах дансанд жилийн 7.2% хүртэл, гадаад валютын харилцах дансанд жилийн 1.2%-ийн хүү боддог. 2021 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2,604.2 мянган төгрөг буюу 47.5%-иар буурсан үзүүлэлтэй байна.

5. Дансны ба бусад авлага

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	/мянган төгрөгөөр/
Дансны авлага	19,608.4	19,608.4	
Татварын авлага			
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			
Нийт дүн	19,608.4	19,608.4	

Дансны авлага нь барьцаагүй, хүүгүй бөгөөд ерөнхийдөө гучин (30) хоногийн дотор буюу төлөгддөг. Авлага нь анхны нэхэмжлэхийн үнээр буюу бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгддөг. Удирдлага нь хэрэглэгч тус бүрийн төлбөр барагдуулах чадварын шинжилгээн дээр үндэслэн худалдааны авлага барагдуулалтыг хянадаг.

6. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	/мянган төгрөгөөр/
Барилга байгууламж			
Машин тоног төхөөрөмж			
Тавилга эд хогшил			
Бусад үндсэн хөрөнгө	32,349.0	32,349.0	
Нийт дүн	32,349.0	32,349.0	

НББОУС 16-д зааснаар Үндсэн хөрөнгийн солилцоо болон буцалтгүй тусламжаар авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бусад тохиолдолд анхны өртгөөр нь бүртгэнэ. Компани үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог.

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

7. Дансны өглөг ба бусад өр төлбөр

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Дансны өглөг	6,350.1	6,350.1
Татварын өглөг	1,543.7	
НДШ-н өглөг	2,399.8	2,399.8
Урьдчилж орсон орлого	6,000.0	6,000.0
Нийт дун	16,293.6	14,749.9

Дансны өглөг нь голчлон хувь хүн ба дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөгөөс бүрдэх ба төлбөрийн нөхцөл нь 30-90 хоногийн хооронд байна. Өглөгтэй байгууллагад сонголт хийж өглөгийн баталгаажуулах захидал явуулж баталгаажуулсан.

8. Хувьцаат капитал

2021 болон 2020 онуудын 12-р сарын 31-нээрх хувьцаат капитал:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Энгийн Хувьцаа		Дун	
	2020	2021	2020	2021
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ			6,310.9	6,310.9
Батлагдсан ба гаргасан	00.0	00.0	6,310.9	6,310.9

9. Ерөнхий удирдлагын зардал

/мянган төгрөгөөр/

Үндсэн дансны иэр	2020.12.31	2021.12.31
Ажилчдын цалингийн зардал		
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал		
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал		
Мэргэжлийн үйлчилгээний зардал		1,060.5
Бусад зардал		
Нийт дун	00.0	1,060.5

Тайланд оны зардал өмнөх оны мөн үеэс 1,060.5 мянган төгрөг буюу 100%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд цалингийн зардал буурсан байна.

10. Санхүүгийн эрсдлийн удирдлагын зорилт болон бодлогууд

Компанийн санхүүгийн эрсдлийн удирдлагын бодлого нь Компанийн үйл ажиллагаанд сергөөр нөлөөлөх байдлыг багасгахын тулд гадаад валютын арилжаа, зээл, төлбөрийн чадварын эрсдэлийг удирдаж байхын зэрэгцээ Компанийн бизнесийг хөгжүүлэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэрийг бий болгохыг эрмэлздэг. Компанийн үндсэн санхүүгийн хэрэглүүрүүд нь зээл ба бэлэн мөнгө зэргээс бүрддэг. Дээрх санхүүгийн өр

төлбөрүүдийн гол зорилго нь Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэх юм. Компанийн дансны авлага, дансны өглөг зэрэг өөрийн үйл ажиллагаанаас шууд үүссэн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөртэй байдаг. Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр, ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж болзошгүй гол эрсдлүүд нь зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, болон гадаад валютын эрсдэл байна.

11. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

Бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо бодит үнэ цэнэтэй санхүүгийн хэрэглүүр

Компанийн 2021 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүд нь бүгд нэг жилээс бага дуусгавар хугацаатай, богино хугацаатай байдаг. Дээр дурьдсан бодит үнэ цэнийн үнэлгээн дээр тулгуурлан эдгээр богино хугацаат санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн санхүүгийн тайлангийн өдрөөрх тооцоолсон бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын тайланц тусгагдсан бүртгэлийн дүнтэйгээ ойролцоогоор гаргаж ирнэ.

12. Капиталын удирдлага

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өр төлбөрөө барагдуулах ба хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино. Компани өөрийн хөрөнгийн бүтцийг удирдан, өөрчлөлт хийхдээ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулдаг. Хөрөнгийн бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувьцаагаа хувьцаа эзэмшигчдэд буцааж өгөх эсвэл шинэ хувьцаа гаргах зэрэг арга замыг ашиглах боломжтой. Компанийн зорилт, бодлого болон үйл ажиллагаанд 2020 болон 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар өөрчлөлт ороогүй болно.